

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 10 сарын 14 -ны өдөр

Дугаар 20/04

Улаанбаатар хот

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн онлайн хурал 10:00 цагт эхлэв.

Хурлын ирц: 100 хувь

Хуралд оролцсон:

1. ТУЗ-ийн дарга П.Батсайхан
2. ТУЗ-ийн гишүүн Б.Батбаяр
3. ТУЗ-ийн гишүүн Сергей Громов
4. ТУЗ-ийн гишүүн Кеннет Чу
5. ТУЗ-ийн гишүүн Сэн И-Ин
6. ТУЗ-ийн гишүүн Томас Холланд
7. ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Батбаяр
8. ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун
9. ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Үнэнбат

Хурлын нарийн бичгийн дарга: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус эчнээ хурал зохион байгуулах комиссын дарга Ч.Ариунсан

Хуралд урилгаар оролцсон:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус эчнээ хурлын Тооллогын комиссын дарга БиДиСек ҮЦК ХХК-ийн брокер Б.Онон;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус эчнээ хурлын зохион байгуулах комиссын гишүүн Хуулийн албаны дарга Э.Солонго;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус эчнээ хурлын зохион байгуулах комиссын гишүүн ТУЗ-ийн Ажлын албаны мэргэжилтэн Б.Мягмар.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн П.Батсайхан хурлыг нээж, хурлын ирц болон хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. АПУ ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус эчнээ санал хураалтын дүнг баталгаажуулах тухай;
 2. ТУЗ-ийн дарга сонгох, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай.
1. **Хэлэлцсэн нь:** АПУ ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус эчнээ санал хураалтын дүнг баталгаажуулах тухай

Танилцуулсан нь:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус эчнээ хурал зохион байгуулах комиссын дарга Ч.Ариунсан: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрийн дагуу эчнээ санал хураалтаар зохион байгуулж, *“ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь бүрэн эрхийг нь дуусгавар болгох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох”* асуудлаар 2020.10.02-ны өдрийн 16:00 цаг хүртэл санал авах ажиллагаа явагдсан бөгөөд Тооллогын комиссын тайланг Тооллогын комиссоос хүлээн авсан. Тооллогын комисс үр дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Онон Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав (хавсаргав).

Шийдвэрийн томъёолол:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 73 дугаар зүйл, АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтын дүн, Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай.

Ердийн гишүүн:

1. П.Батсайхан
2. Б.Батбаяр
3. Сергей Громов
4. Кеннет Чу
5. Сенг И-Инг
6. Томас Холланд

Хараат бус гишүүн:

1. Ө.Батбаяр
2. Ё.Гэрэлчулуун
3. Ж.Үнэнбат

Санал хураалтын дүн: 100% дэмжсэн.

№	ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүд	Санал		
		Дэмжсэн	Дэмжээгүй	Түдгэлзсэн
1	П.Батсайхан	*		
2	Б.Батбаяр	*		
3	Сергей Громов	*		
4	Кеннет Чу	*		
5	Сэн И-Ин	*		
6	Томас Холланд	*		
7	Ө.Батбаяр	*		
8	Ё.Гэрэлчулуун	*		
9	Ж.Үнэнбат	*		

2. **Хэлэлцсэн нь:** ТУЗ-ийн дарга сонгох, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай

Танилцуулсан нь: ТУЗ-ийн дарга сонгох

ТУЗ-ийн гишүүн Б.Батбаяр ТУЗ-ийн даргад П.Батсайханыг сонгохыг санал болгов.

Шийдвэрийн томьёолол: ТУЗ-ийн даргаар Пүрэв овогтой Батсайханыг сонгосугай.

Санал хураалт: П.Батсайхан түдгэлзэн, 8 гишүүн санал өгч, 89 хувьтайгаар санал дэмжигдэв.

№	ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүд	Санал		
		Дэмжсэн	Дэмжээгүй	Түдгэлзсэн
1	П.Батсайхан			*
2	Б.Батбаяр	*		
3	Сергей Громов	*		
4	Кеннет Чу	*		
5	Сэн И-Ин	*		
6	Томас Холланд	*		
7	Ө.Батбаяр	*		
8	Ё.Гэрэлчулуун	*		
9	Ж.Үнэнбат	*		

Танилцуулсан нь: ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороодын чиг үүрэг болон хороодын бүрэлдэхүүнд тавигдах хуулийн шаардлагуудыг танилцуулав.

Шийдвэрийн томьёолол: ТУЗ-ийн дэргэдэх дараах хороодыг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Аудитын хороо:

1. Ж.Үнэнбат (Хорооны дарга)
2. Сэн И-Ин
3. Ө.Батбаяр

Нэр дэвшүүлэх хороо:

1. П.Батсайхан (Хорооны дарга)
2. Ө.Батбаяр
3. Ё.Гэрэлчулуун

Цалин урамшууллын хороо:

1. Ё.Гэрэлчулуун (Хорооны дарга)
2. Ж.Үнэнбат
3. Кеннет Чу

Санал хураалтын дүн: 100% дэмжсэн.

№	ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүд	Санал		
		Дэмжсэн	Дэмжээгүй	Түдгэлзсэн
1	П.Батсайхан	*		
2	Б.Батбаяр	*		
3	Сергей Громов	*		
4	Кеннет Чу	*		
5	Сэн И-Ин	*		
6	Томас Холланд	*		
7	Ө.Батбаяр	*		
8	Ё.Гэрэлчулуун	*		
9	Ж.Үнэнбат	*		

Хурлаас гарсан шийдвэр:

1. Тооллогын комиссын тайланг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнг ТУЗ-ийн тогтоол гаргаж баталгаажуулах;
2. ТУЗ-ийн дарга сонгож, ТУЗ-ийн дэргэдэх хороод байгуулсныг ТУЗ-ийн тогтоол гаргаж баталгаажуулах.

Хурлыг хаав.

Хурал 11 цаг 00 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Ч.Ариунсан

Хянасан:

ТУЗ-ийн дарга

П.Батсайхан



**“АПУ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 06 өдөр


№ 1

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 73 дугаар зүйлийн 73.7, компанийн дүрмийн 7.11, тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АПУ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 1,011,939,319 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 17 хувьцаа эзэмшигч эчнээ санал хураалтанд оролцож, нийт саналын эрх бүхий 1,064,181,553 ширхэг энгийн хувьцааны 95.09% болж байгааг мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 73.7, компанийн дүрмийн 7.11 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 95.09%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга:



/Б.Онон/

Тооллогын комиссын гишүүн:



/Э.Эрхэмзаяа/

/Б.Түвшинбаяр/

“АПУ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2020 оны 10 сарын 06 өдөр

Улаанбаатар хот

“АПУ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

“АПУ” ХК-ийн саналын эрхтэй нийт 1,064,181,553 ширхэг хувьцаанаас 95.09% буюу 1,011,939,319 ширхэг хувьцаа эзэмшиж буй 17 хувьцаа эзэмшигч эчнээ санал хураалтад оролцов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. “АПУ” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох
2. “АПУ” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Хурлаар дараах асуудлыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. “АПУ” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох тухай асуудалд эчнээ санал хураалтаар санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн ирц 100%, үүнээс 99.994466 % буюу 1,011,883,319 ширхэг хувьцаатай 16 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчинтэй байв.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	хувь
1,011,883,319.00	100.00%	0.00	0.00%	0.00	0.00%

Тус асуудалд хүчинтэй санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох тухай асуудлыг **ЗӨВШӨӨРСӨН** шийдвэр гарав.

Хүчингүй саналын тоо:

Дээрх асуудалд 1 саналын хуудас гарын үсэг дутуу зурагдсаны улмаас хүчингүйд тооцов.

№	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Хувьцааны тоо	Хувь	Тайлбар
1	О.Баяраа	56,000.00	0.01%	Гарын үсэг дутуу

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

2. “АПУ” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлыг эчнээ санал хураалтаар санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн ирц 100%, үүнээс 100 % буюу 1,011,939,319 ширхэг хувьцаатай 17 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчинтэй байв. Хүчингүй саналын хуудас байгаагүй болно.

Тус асуудалд хүчинтэй санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар “АПУ” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлыг **ЗӨВШӨӨРСӨН** шийдвэр гарав.

Ердийн гишүүдэд

	ТУЗ-ийн ердийн гишүүний овог, нэр	Кумулятив аргаар өгсөн саналын тоо	Саналын хувь
1	Томас Холланд	1,726,899,531	28.44%
2	П.Батсайхан	870,621,741	14.34%
3	Б.Батбаяр	868,534,917	14.31%
4	Кеннет Чу	868,531,040	14.31%
5	Сэн И-Ин	868,531,040	14.31%
6	Сергей Громов	868,517,643	14.31%
	Нийт	6,071,635,912	100.00%

Хараат бус гишүүдэд

	ТУЗ-ийн хараат бус гишүүний овог, нэр	Кумулятив аргаар өгсөн саналын тоо	Саналын хувь
1	Е.Гэрэлчулуун	1,011,937,446	33.33%
2	Ж.Үнэнбат	1,011,936,443	33.33%
3	Ө.Батбаяр	1,011,935,440	33.33%
	Нийт	3,035,809,329	100.00%

Тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдэд шинээр сонгогдов. Үүнд:

Ердийн гишүүнд:

1. Томас Холланд
2. П.Батсайхан
3. Б.Батбаяр
4. Кеннет Чу
5. Сэн И-Ин
6. Сергей Громов

Хараат бус гишүүнд:

7. Е.Гэрэлчулуун
8. Ж.Үнэнбат
9. Ө.Батбаяр

Тооллогын комиссын дарга:

/Б.Онон/

Тооллогын комиссын гишүүн:

/Э.Эрхэмзаяа/

/Б.Түвшинбаяр/